

# ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 12 сарын 26 өдөр

Дугаар 11

Улаанбаатар хот

## Санхүүгийн тайланд аудит хийх хөндлөнгийн аудитын байгууллага сонгох тухай

Монгол улсын компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.10 дахь заалт, Тандэм Инвэст ББСБ ХК-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.2.12.9 дахь заалтыг үндэслэн Төлөөлөн Удирдах зөвлөлөөс **ТОГТООХ** нь:

1. “Тандэм Инвэст ББСБ” ХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хөндлөнгийн аудит хийх байгууллагаар “Шинэ их тэрбум аудит” ХХК-ийг сонгосугай.
2. “Шинэ их тэрбум аудит” ХХК-тай байгуулах гэрээний нөхцөлийг хэлэлцэн тохирох, гэрээ байгуулах, гэрээнд гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирал /Ж.Ганхүлэг/-д олгосугай.
3. Хөндлөнгийн аудитын байгууллагыг төлөвлөсөн хугацаанд ажиллах нөхцөл боломжоор хангаж, хамтарч ажиллах, шаардлагатай мэдээлэл, баримт материалыг гаргаж өгөх, тайланг төлөвлөсөн хугацаанд нийтлэхэд шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлж ажиллахыг Гүйцэтгэх захирал /Ж.Ганхүлэг/-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ч.ЧИНЗОРИГ

# ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 12 сарын 26 өдөр  
хот

Дугаар 12

Улаанбаатар

## Компани нэгтгэх бэлтгэл ажилтай холбоотой хамтран ажиллах байгууллагуудтай гэрээ байгуулах, сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17, 76.1.18, 76.2 дахь заалт, 80 дугаар зүйлийн 80.2, 80.7-д заасныг, “Тандэм Инвэст ББСБ” ХК-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.2.12.9 дэх заалтыг тус тус үндэслэн Төлөөлөн Удирдах зөвлөлөөс **ТОГТООХ** нь:

1. “Рэйн Жи Ти Си” ХХК-тай нэгтгэх асуудалтай холбоотой ажлын хүрээнд Аудит, Хуулийн компанитай гэрээ байгуулан хамтран ажиллах эрхийг олгосугай. Тус компаниудаас ирүүлсэн дүгнэлтүүдэд үндэслэн гэрээ, журам, төслийг Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулахад бэлэн болгохыг Гүйцэтгэх захирал /Ж.Ганхүлэг/-д үүрэг болгосугай.
2. “Рэйн Жи Ти Си” ХХК-тай нэгтгэх ажлын хүрээнд Зөвлөх үйлчилгээг “Сикап ҮЦК ХХК”-тай гэрээ байгуулан хамтран ажиллахыг зөвшөөрсүгэй.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА.  Ч.ЧИНЗОРИГ

